



ҮНДЭСНИЙ НЭР ТОМЬЁОНЫ СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ АСУУДАЛД

О.Мягмарсүрэн
МУБИС-ийн НХУС-ийн Гадаад хэлний төвийн багш

Abstract: We have not developed any standards to define the detailed knowledge of the terminologies and language processing. That's why we use a single object and concept designated in many ways. Overlapping of terms and concepts in different definitions increases the risk of getting problems in relations to the different understanding between professionals. Nowadays, science and technology have been rapidly developing and new knowledge has dramatically been created, but we could not determine the complexity of concepts in our own language. Visionary science and research-based language policy and its implementation cannot support the development of the Mongolian language.

In order to develop terminology database of any fields, we need a number of field experts to develop co-operation and their active participation is necessary. Scientists can solve this issue using information technology by opening e-forum and many people participate in the various fields. In this article, we presented the linguistic analysis of National Standard of Terminologies concerning the need of the development of the renewable energy sector and its findings.

Түлхүүр үг: стандарт, үндэсний стандартчилал, нэр томьёо судлал

Удиртгал

Орчин цагт шинжлэх ухаан, технологи хурдтай хөгжиж, шинэ мэдлэг эрс нэмэгдэж байгаатай зэрэгцэн нарийн төвөгтэй ухагдахууныг өөрийн хэл дээр бүрэн гүйцэт оноож тогтоож чадахгүй байгаа нь монгол хэлний хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан,

судалгаанд суурилсан алсын хараатай хэлний бодлого төлөвлөлт хийх, түүнийг хэрэгжүүлэх ажил дутагдаж байна гэсэн үг. Нэр томьёоны давхцал нэмэгдэх, ухагдахууны тодорхойлолт ташаарахын хирээр нэг салбарын мэргэжилтнүүдийн хооронд ойлголцлын зөрүү гарч, харилцаанд бэрхшээл учрах эрсдэл нэмэгддэг.

Үндэсний нэр томьёоны стандарт боловсруулах хэрэгцээ шаардлагаас үүдэн энэхүү өгүүлэлд сэргээгдэх эрчим хүчний салбарын нэр томьёог хэрэглээний хэл шинжлэлийн үүднээс задлан шинжлэх оролдлого хийсэн үр дүнг танилцуулж байна.

Шинжлэх ухаан бүр өөр өөрийн нэр томьёоны сантай. Харин нэр томьёо ухагдахууныг тодорхой зааж, шинжлэх ухааны хэлийг нарийн дэгтэй болгодог онцлогтой. Шинжлэх ухааны хэл бүрэлдсэнээр тогтсон нэр томьёогоор ярьж, бичих нь зүй ёсных болдог. Шинжлэх ухаан, техникийн хувьсгалын улам хурдасч буй хөгжлийн явц хүн төрөлхтөний үйлдвэрлэлийн болон эрдэм шинжилгээний бүхий л хүрээг хамарсан мэдээлэл эрс өсөхөд хүргэж байна. Ингэснээр олон шинэ ухагдахуун нэмэгдэж, түүнийг даган хэлэнд шинэ нэр томьёо гарч ирэхэд хүргэдэг.

Нэр томьёо нь утга зохиолын хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнийг баяжуулах гол эх булаг болдог учраас нэр томьёог эмхлэх, зохицуулах асуудал эрдэм шинжилгээний болон нийгмийн ач холбогдолтой болсоор байна.

Шинжлэх ухаан, техникийн нэр томьёог тогтоох үүднээс журамлан загварчлахын тулд тухайн хэлний

хөгжлийн зүй тогтол, нийт утга зохиолын хэлний тогтсон норм, хэл ярианы соёлын орчин үеийн түвшинд тохирсон нэгдсэн зарчим, шалгуурыг тогтоох шаардлагатай. Энэ нь нэр томъёог зөв тогтоох, тогтсон нэр томъёог улам боловсронгуй болгох гол баримжаа болно.

Сүүлийн үед манай улс оронд шинэ техник технологи өргөн нэвтэрч, нэр томъёо болон шинжлэх ухаан тасралтгүй хөгжихийн хэрээр гадаад үг хэллэг олноор орж ирж байна. Үүнийг төрөлх хэл дээрээ оноох, тоймлох, жигдлэх асуудал чухал юм. Монгол хэл дээрх шинжлэх ухаан, техник технологийн нэр томъёог жигдлэх ажил 1930-аад оны сүүлээс эхлэн, өнөөг хүртэл хийгдэж байгаа боловч үүнийг цаашид улам боловсронгуй болгох, олон улсын нэр томъёог зөв хэрэглэх, жигдлэх, оновчтой оноох зэрэг асуудлууд гарч ирсээр байна. Бараг далаад жил нэр томъёог жигдлэх ажил хийгдсээр ирсэн гэж үзвэл нийтдээ 120-н мянга орчим нэр томъёо боловсруулан, УНТК-оор батлуулсан гэсэн тооцоо бий. Гэтэл энэ тоо зөвхөн Канад улсын интернэт хаягт буй стандартчилагдсан 4 сая орчим нэр томъёоны хажууд дуслын төдий зүйл болж байна. Ийнхүү нэр томъёог нэгдмэл болгон жигдлэх, оновчтой оноох ажил нь хэл шинжээч, нэр томъёоч нар болон шинжлэх ухаан, техник технологи, аж ахуйн олон салбарын мэргэжилтнүүдийн хамтын хүчин чармайлтаар бүтэх нарийн ажил юм.

Монгол Улсын Их хурал 2015 онд “Монгол хэлний тухай” хуулийг шинэчлэн баталсан ба тус хуулийн хамгийн үнэ цэнэтэй заалт бол бид анх удаа монгол хэлээ хөгжүүлэх, төгөлдөржүүлэх, судлах, бодлого төлөвлөлтийг хийх ажлыг хариуцах эрх бүхий этгээд нь ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн болно гэдгийг хуульчлан тогтоож өгсөн явдал хэмээн үзэж байна.

Үндэсний нэр томъёоны стандарт боловсруулах асуудалд

“Стандарт” гэх нэр томъёо хэл судлаачид, сонирхогчдын дунд өргөн дэлгэр хэрэглэгдсээр иржээ. Стандарт (standard) гэсэн үг нь

1. Жишиг, түвшин
2. Хэм хэмжээ норм
3. Шалгуур үзүүлэлт гэсэн утгатай талаар олон хэлний тольд бичсэн байдаг.

Гэхдээ “norm” ”standard” гэсэн энэ хоёр үг үгчилбэл “хэм хэмжээ” гэсэн нэгэн ижил утгаар Франц, Герман зэрэг зарим улс оронд хэрэглэгддэг.

Монгол хэлний хувьд эдгээр үгсийг ялгаатай хэрэглэж байгаа нь norm- хэлний хэм хэмжээ, standard-жишиг буюу стандарт гэдгээр оноосноос харагддаг.

Харин нэр томъёо судлалд хэм хэмжээ гэхээсээ нэр томъёоны шаардлага, зарчим, нэр томъёоны стандарт гэж түгээмэл хэрэглэх нь зохистой юм. Нэр томъёо нь хэлний бааз суурь дээр хөгжиж өөрийн жишиг буюу стандарттай онцлог салбар билээ. Нэр томъёоны стандарт бол хэм хэмжээтэй харьцуулахад тогтсон мэт атлаа хөдлөшгүй тогтолцоо бас биш юм. Хэлний хэм хэмжээний адил нийгэм, цаг үеийн аясаар алгуур өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг үзэгдэл юм. (Шинэбаяр, 2012)

Тухайн улс үндэстний төдийгүй олон улсын хэмжээнд дагаж мөрдөх стандарт гэж байна. Манай улсын хувьд үндэсний стандартын тэмдэглэгээг нь MNS гэх ба улс бүрийн үндэсний стандартын байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн Олон улсын стандартын байгууллага буюу “International standardization organization” нь ISO гэсэн тэмдэглэгээг хэрэглэдэг. Бараа бүтээгдэхүүний стандартаас гадна бичиг үсгийн хувьд ч нийтээр даган мөрддөг стандарт бий. Жишээ нь: Латин үсгийн стандартыг үүнд нэрлэж болно. Стандартгүй дэлхий ертөнцийг төсөөлшгүй. Орчин үед дэлхийн маш олон хүчин зүйлүүд стандартаас хамаарч байна. (Эрдэнэцэцэг, 2011, х.2) Бид юмсын “Стандартыг бүтээх” эринээс “Юмсыг хийх стандартын” эрин рүү улам их ойртож байна. Стандарт бол хүн төрөлхтний үйлдвэржилтийн гурван том хувьсгалын нэг юм. Бараа бүтээгдэхүүнийг бөөнөөр үйлдвэрлэх боломж олгосон анхны алхам нь стандартжуулах явдал байсан бол түүний дараа механикжуулах систем



үйлдвэрлэлд нэвтэрсэн байна. Нэр томьёог ч гэсэн эхлээд стандартжуулж дараа нь механикжуулах буюу цахим хувилбарт шилжүүлж болох юм.

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай монгол улсын хуулийн 3.1-д дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

3.1.1. “Стандартчилал” гэж бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ (цаашид “Бүтээгдэхүүн” гэх)-ний харилцан орлолт, аюулгүй байдал, мэдээлэл, техник, хэмжилт, сорилын нийцтэй, нэгдмэл байдлыг хангах зорилгоор нийтлэг бөгөөд дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг;

3.1.2. “Стандарт” гэж бүтээгдэхүүний үзүүлэлт, шаардлагын хэм хэмжээг зохих журмын дагуу сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж, эрх бүхий байгууллагаас баталсан норматив-техникийн баримт бичгийг;

Стандарт гэдэг нь бүтээгдэхүүний үзүүлэлтэнд шаардлага тогтоож, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагаар батлуулсан баримт бичиг юм. Харин стандартчилал гэдэг бол нийтлэг, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагаа. (Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо, MNS1-2:2006, х. 23)

Эндээс дүгнэхэд стандартчилал бол үйл ажиллагаа, харин стандарт бол баримт бичиг юм гэж товчоор ойлгож болно. Үндэсний стандартчиллыг боловсруулах гол байгууллагуудын нэг нь Стандартчилал хэмжилзүйн үндэсний төв юм. Стандартчилал хэмжилзүйн үндэсний төв (СХҮТ) нь олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үндэсний стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхлэн явуулдаг. Улсын стандарт боловсруулах ажлыг тус төв нь холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороогоор хэлэлцэж, дэмжигдсэн стандартын төсөл нь СХҮТ-ийн Зөвлөлийн тогтоолоор батлагдсанаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Нэр томьёоны стандартчилалагуулгаараа

шинжлэх ухаан, техникийн дэвшилд түлхэц үзүүлэх гэсэн зорилгод багтаж байдаг.

Үндэсний стандартыг батлуулах төслийг техникийн хороо (дэд хороо)-ны дарга нар хариуцан стандартчилал хэмжилзүйн үндэсний зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлнэ. Стандартчилал хэмжилзүйн үндэсний зөвлөлийн хуралд оруулж байгаа үндэсний стандартыг батлуулах төсөлд дараах материалуудыг дагалдуулна. Үүнд: Техникийн хорооны шийдвэр, стандартчилал хэмжилзүйн үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл, стандартын төслийн тухай танилцуулга, болон бусад материал орно.

Стандартыг баталснаас хойш 20 хоногийн хугацаанд багтаан зохих засвар, тодотгол оруулан тогтоолын хамтаар стандартын төв байгууллагын мэдээлэл, лавлагааны төв (стандартын мэдээллийн төв)-д хүлээлгэн өгнө.

Батлагдсан стандартыг стандартын мэдээллийн төв хүлээн авч, холбогдох ажилтан улсын бүртгэлд бүртгэж, “Үндэсний стандарт, баримт бичгийн катологи”-д 10 хоногт багтаан тусгана. Эндээс дүгнэхэд манай оронд нэг салбарын тухайн нэг төрлийн нэр томьёоны стандарт батлахад нүсэр их ажил, цаг хугацаа шаардагдаж байгаа төдийгүй хэлний талаар баримтлах бодлого, өндөр технологи, шинэ үеийн техникийн хөгжлийн үр дүнд үүсч бий болж байгаа шинэ ухагдахууныг илэрхийлдэг нэр томьёо тогтоох асуудлаар хийсэн бодитой ажил, гарсан үр дүн хангалтгүй байгаа бөгөөд улмаар төрийн хэлний бодлого, зохицуулалт, шинээр нэр томьёо тогтоох үйл ажиллагааны хурд бодит хэрэгцээ шаардлагаас хоцорч байгаа гэдэгтэй санал нэг байна.

Үндэсний стандартын төрлүүд:

Бүтээгдэхүүний стандарт- 40%

Нэр томьёоны стандарт- 3%

Суурь стандарт – 16%

Сорил, туршилтын стандарт- 41% байдаг бол хамгийн бага стандартчилагдсан нь нэр томьёо гэсэн төрөл байгаа нь илт харагдаж байна.

Монгол улсын стандартын жагсаалт 2013, үүнээс үзвэл шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийн явцад нэр томьёо асар олноор бий болж, тэр нь тухайн салбартаа түгэн хэвшиж, олон нийтэд нэгдсэн ухагдахууныг цогцлуулснаараа шинжлэх ухаан, техникийн хөгжил дэвшилд эргээд нөлөөлөх чадавхитай хүчин зүйлийн нэг болсон тэрхүү олон нэр томьёо нэг мөр болж стандартчилагдаж чадахгүй байна. Гэхдээ өөрийн хэлэнд нийцүүлэн зөв бичиж хэвшүүлэх явдал нэн чухал. Урьд нь дан ганц орос хэлээс нэр томьёог эх авахдаа бараг оросоор дуудах шахам байсан бол өнөө үед англиар шууд хэрэглэх нь улам бүр ихсээд байна. Сэргээгдэх эрчим хүчний герег, латин гаралтай англижсан нэр томьёог монгол хэлэнд буулгахад тэдгээр хэлний үгийн угтвар, язгуур, дагаврыг хэрхэн орчуулсныг зарим жишээгээр үзүүлье: centralized electrical supply- төвлөрсөн цахилгаан хангамж, non centralized electrical supply төвлөрсөн бус цахилгаан хангамж, (non- бус, heating- дулаанжуулалт, -ing- уул² +лт)

Дээрх жишээнээс үзэхэд герег, латин гаралтай үгийн угтвар, язгуур, дагаврын иймэрхүү орчуулга, цаашдаа эдгээрээс илүү оновчтой хувилбар нь орчин цагийн сэргээгдэх эрчим хүчийг эхлэн судалж байгаа оюутан суралцагчид болон нийт уншигч олонд харь хэлний нэр томьёоны утга учрыг төрөлх хэлээрээ ухаарч ойлгоход болон тухайн салбарын мэдлэгийг нийт хүмүүст түгээх зорилгоор ашиглахад хэрэгтэй юм.

Нэр томьёоны стандартчилал, түүнийг оноон жигдлэх талаар манай эрдэмтэд янз бүрийн санал дэвшүүлсэн байдаг. Үүнд:

Доктор профессор Балдан.Л. “Нэр томьёог нөхөх, үл нөхөх зарчмаар судлах нь” хэмээх өгүүлэлдээ “Эх хэлнийхээ үг холбох боломжид тулгуурлан хоёр үгээр бүтсэн зарим нэр томьёог хамт бичиж хэвшүүлбэл холбоо үгээс ялгахад хялбар болно” гэсэн санааг дэвшүүлсэн байна. (2005, х. 12) Түүний дэвшүүлсэн санааг дэмжин энэхүү судалгаандаа “Нэр томьёо” гэсэн үг болон

бусад хоёр үгээс бүтсэн нэр томьёог хамтад нь бичсэн болно. Нэр томьёог бүтээж буй хам нийлэмжээрээ нэг утга санааг илэрхийлж байвал хамт бичих нь нэн чухал зарчмын нэг төдийгүй чухамдаа олон улсын нэр томьёоны хамгийн түгээмэл зарчмыг мөрдөж буй хэрэг юм.

Доктор Баярсайхан.Ё. “Нэр томьёоны тулгамдсан асуудалд” гэсэн өгүүлэлдээ “Орчин үеийн нэр томьёоны чухал асуудал нь:

- Орчин цагийн монгол хэлний хөгжил, монгол хэлний нэр томьёог цаашид улам боловсронгуй болгох
- Нэгэнт үүссэн нэр томьёоны системийг цаашид улам боловсронгуй болгох, хөгжүүлэх, үүнд янз бүрийн нэр томьёоны толийг цаашид улам хянан сайжруулж, орчин үеийн шаардлагатай уялдуулан байнга шинэчлэн нэмж засварлан дахин хэвлүүлж байх,
- Нэр томьёог тогтоохдоо гадаад үгийг тэр хэвээр нь хэрэглэхээс аль болох зайлсхийх зарчим баримталж байна” (2005, х. 13) гэжээ.

Тэрээр мөн нэр томьёоны ард ямар салбар хамааралтайг нь заах нь зүйтэй гэсэн байна. Энэ нь тун зөв зүйтэй санал юм. Учир нь Канадын 3 сая 900 мянган нэр томьёоны арвин баялаг сантай цахим санд орсон бүх нэр томьёонд шинжлэх ухааны ямар салбарт хамааралтай байдгийг нь тодорхойлсон байдаг төдийгүй ямар эх сурвалжаас авсан болохыг нь тэмдэглэж ухагдахуун тус бүрийн тодорхойлолтыг хавсаргасан байдаг байна. Жамба 2005, “Нэр томьёоны үндсэн зарчимд өөрийн гэсэн тогтолцоо, тодорхойлолттой, хэрэглээний салбартай, чадвал мэргэжлийн салбар дундын шинжтэй байх, сэтгэл хөдлөлийн илрэлгүй, хэл найруулгын хувьд төлөв байх зэрэг шаардлагыг хамаадуулсан байдаг” хэмээн дурджээ. Мөн Өнөрбаян.Ц. (2005, х. 86) “Шинжлэх ухаан технологийн хөгжил дэвшил улам бүр эрч хүчтэй болохыг дагалдан тодорхой шинжлэх ухааны нэр томьёог зөв оновчтой тогтоох, стандартчилах, загварчлах асуудал чухал



болж байна. Нэр томьёог зөв оновчтой тогтооно гэдэг нь учир зүйн болон хэл шинжлэлийн үүднээс тухайн ухагдахууныг зөв тэмдэглэх, стандартчилах, загварчлах гэдэг нь шинжлэх ухааны салбаруудын ижил төрлийн ойлголтыг адил загварт бүтцээр болон хэмнэлттэй товч тэмдэглэх, өөрөөр хэлбэл нэр томьёог интеграцчилахыг ойлгож болно. Энэ нь шинжлэх ухааны мэдээллийг боловсруулах, жишиг хэмжүүртэй болгоход практик ач холбогдолтой юм” гэсэн бол Гэрэлмаа.Г. “Нэр томьёог оноон тогтоох, жигдлэхийн тулд түүнд тавигдах шаардлагыг сайтар мэдэх хэрэгтэй. Шаардлагын талаар нэр томьёо судлаачид

1. Товч байх,
2. Ганц утгатай байх,
3. Ойролцоо утгатай үггүй байх,
4. Сэтгэл хөдлөлийн өнгө аясгүй байх,
5. Оновчтой байх,
6. Зөв, дуудахад эвтэйхэн,
7. Гоо зүйн шаардлагад нийцсэн байх зэргийг харгалзан үзэхийг чухалчилдаг” хэмээжээ. (2009, х. 77)

Эндээс дүгнэвэл нэр томьёог боловсруулж оноон жигдлэнэ гэдэг нь учирзүйн болон хэл шинжлэлийн үүднээс тухайн ухагдахууныг зөв тэмдэглэх, шинжлэх ухааны нэр томьёог боловсруулан сайжруулах, нэг мөр болгож стандартчилахдаа өөрийн хэлний онцлогт тохируулан төвлөрүүлж буй түүхэн туршлагыг мөрдлөг болгон ашиглах, олон түмний ой тойнд нийцүүлэн хэвштэл нь хэрэглэх явдал юм.

XX зууны шинжлэх ухааны нэр томьёог тогтоохдоо салангид ухагдахууныг тус тусад нь оноож нэрлэх, дэлгэрэнгүй тайлбарласан нийлмэл үгээр тогтоох, хуулбарлан орчуулах, олон улсын нэр томьёог шууд авч хэрэглэх зэрэг аргыг хэрэглэж байсан бол сүүлийн жилүүдэд тухайн шинжлэх ухааны ухагдахууныг тогтолцоот талаас нь стандартчилан нэр томьёо оноох, олон шинжлэх ухааны нэг төрлийн ухагдахууныг иж бүтэцтэй нэр томьёогоор оноон загварчилах хандлагатай болжээ. Өнөөдөр манай улсад шинжлэх ухааны ихэнх салбар нэр томьёоны баялаг сантай болсон боловч

нэг ухагдахууныг өөр өөр үгээр тэмдэглэх, өөр өөр ухагдахууныг нэг үгээр илэрхийлэх, оновчтой нэг үгээр тэмдэглэх ухагдахууныг олон үгтэй тайлбар нэрээр оноох зэрэг дутагдал түгээмэл байна. Иймээс шинжлэх ухааны нэр томьёог тухайн нэг салбар ухааны хүрээнд төдийгүй хэд хэдэн салбарын төвшинд стандартчилан цэгцлэх шаардлагатай болж байна.

Алив нэг салбарын нэр томьёоны санг боловсруулахын тулд нилээд хэдэн салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, олон хүмүүсийн идэвхтэй оролцоо шаардлагатай болох учир өнөө үед энэ асуудлыг шийдэхдээ мэдээллийн технологийг ашиглавал олон салбарын эрдэмтэд оролцох, нээлттэй цахим хэлэлцүүлэг хийх өргөн боломж бүрдэнэ.

Нэр томьёог олонд хүргэх, хэлэлцүүлэх гол арга хэрэгсэл нь нэр томьёоны мэдээлэл юм. Нэр томьёоны цуврал мэдээллийг байнга гаргаж байх тогтолцоог бий болгосноор төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийн дунд өргөн хэлэлцүүлэг явуулан нэр томьёог нэг мөр болгон хэвшүүлэх, зарим нэр томьёоны орчуулгыг оновчтой болгон залруулах бодит боломж бүрдэх юм. Тиймээс нэр томьёоны бодлого төлөвлөлт зайлшгүй чухал юм. Зарим тодорхой салбараар зөвлөх шинжтэй нэр томьёоны стандарт зохиож батлуулан түүнийг мөрдөх хэрэгтэй. Жишээ нь: дулааны эрчим хүчээр MNS 5085:2001, уурын зуухаар MNS 5086:2001, ус халаах зуухаар MNS 5087:2001 гэх мэт 161 нэр томьёоны стандартууд байгаа боловч үндэсний нэр томьёоны стандарт боловсруулахад үнэхээр хангалтгүй байна.

Мөн одоог хүртэл бүрэлдэн тогтсон нийт нэр томьёоны цахим санг хийх шаардлага гарч байна. Ийнхүү компьютерийн боловсруулалт хийснээр шинжлэх ухаан техник технологийн салбар бүрт хамаарагдах утга, ухагдахуун давхацсан нэр томьёог цэгцлэн стандартчилах эхний алхам бий болно.

Нэр томьёо судлаач Ч. Догсүрэн “Нэр томьёоны жигдлэгээ нь дотроо тоймлон хэлбэл:

1. Салбар доторх
2. Салбар хоорондын

3. Улс доторх

4. Улс хоорондын гэх мэт ялгаа буюу (үе шат)-тай байдаг” (1988, х. 24) гэсэн бол Д. Дашдаваа нар “Нэр томьёо шинжлэх ухааны тодорхой салбарт үйлчилдэг хүний мэдлэгийн янз бүрийн салбарт нэг нэр томьёо зарим тохиолдолд өөр өөр утгаар хэрэглэгдэж болно” гэжээ. (1977, х. 21). Өөрөөр хэлбэл нэг нэр томьёо өөр өөр салбарт, өөр өөр ухагдахуунаар хэрэглэгдэж болно. Тухайлбал: Сэргээгдэх эрчим хүчний усны эрчмийн салбарт “Head” хэмээх нэр томьёо “Түрлэг” гэсэн утгатай байхад техникийн салбарт “Head of cylinder-цилиндрийн блокны таг”, “Screw head-боолтны тав”, анагаах ухаанд “come to a head-идээлэх” гэсэн утгатай байна.

Нэр томьёоны хос нэршлийг нэр томьёо болгон хэрэглэх тухайд судлаачид харилцан адилгүй саналтай байдаг ч зөрөөтэй нэр, ойролцоо нэр томьёо байж болохгүй талаар нэгдмэл бодолтой байдаг.

Үүнээс харахад нэр томьёог нэгдмэл болгон жигдлэх асуудлыг юуны өмнө салбар доторх, салбар хоорондын, улсын доторх, улс хоорондын гэсэн хэдэн үе шаттайгаар авч үзэн хэрэгжүүлбэл зохистой юм. Бусад улс орны туршлагаас үзэхэд ихэнх улс орон эхний гурван шатны нэр томьёоны асуудлыг бараг шийдвэрлэхийг дээрх дөрвөн шатны эцсийн шатан дээр (улс хоорондын) явж байна. Манай улсын хэмжээнд нэр томьёо салбар дотроо ч жигдрээгүй байгаа нь нэг юм үзэгдэл, ойлголтын нэр олон болох, улмаар ойлгомжгүй болж бусад нэр томьёотой давхцах, утга ташаарах, ингэснээр салбарын дотор мэргэжилтэн хоорондоо ойлголцоход бэрхшээл учирна. Үүнийг шийдвэрлэх гол арга зам нь олон улсын нэр томьёоны байгууллага ISO (International Organization for Standardization), олон улсын нэр томьёо судлалын хороо ICTUN International Committee for Unification of Terminological Neologism) – ны стандарчилалын дагуу оновчтой орчуулан Монгол Улсын Үндэсний Стандартаар батлуулан мөрдөх явдал гэж үзэж байна. Олон улсын нэр томьёоны байгууллагаас батлан гаргасан нэр томьёоны ажлын 3

стандарт байдаг. Үүнд:

1. Нэр томьёо боловсруулах зарчим болон арга – ISO 704:2009
2. Нэр томьёоны ухагдахууныг жигдлэх – ISO 860:2007
3. Нэр томьёо- үгийн сан, онол болон хэрэглээ- ISO 1087-1:2000

Нэр томьёоны ажил нь олон талт ажил бөгөөд мэргэжлийн чиглэл, түүний судалгаа, тусгай хэл, ерөнхий хэлний төлөөлөл (жишээ нь логик, танин мэдэхүйн онол, шинжлэх ухаан, хэл зүй, орчуулгын судалгаа, мэдээлэл, танин мэдэхүйн шинжлэх ухаан, шинжлэх ухааны философи) тэдгээрийн үзэл баримтлалын судалгаа юм. Энэ нь тодорхойлолт, ангилал, мэдлэг дамжуулах зэрэг онолын элементүүдийг хослуулсан байдаг.

Ойролцоо утгатай нэр томьёо хэт олширвол нэр томьёоны боловсруулалт дутуу дулимаг байгааг гэрчилдэг. Мөн мэргэжилтнүүд ойлголцоход бэрхшээл учирна. Стандартчлал, Хэмжил зүйн Үндэсний Төв Стандарт батлахдаа ойролцоо утгатай зарим нэр томьёог давхардуулан хэрэглэж болохгүй гэж үзэн мөрддөг. Энэ нь нэр томьёог жигдлэхэд чухал түлхэц өгч байгаа нэгэн сайн жишээ юм.

Сүүлийн жилүүдэд хэл шинжлэлийн бус салбарын эрдэмтэд, судлаачид, мэргэжилтнүүдийн нэр хөдөлмөр, идэвх санаачилгын ачаар олон тооны нэр томьёоны толь хэвлэгдэн гарч олны хүртээл болж байгаа нь сайшаалтай хэдий ч бид нэр томьёог боловсруулах ажлын үндэсний стандартуудыг одоо болтол гаргаагүй тул алдаамадагтай зүйл олон байгаад тэдгээрт толь бичиг зохиогчдыг буруутгах аргагүй. 1990 оноос хойш нийт 71 орчим нэр томьёоны толь хэвлэгджээ. Эдгээр толь бичгүүдэд нэр томьёоны ухагдахууны тайлбар тодорхойлолт байхгүй, нэг нэр томьёог олон янзаар оноосон байна. Нэгэнт хэвлэгдэж олны хүртээл болсон нэр томьёонууд зөв буруу, алдаа мадагтай чигээрээ ард түмний үгийн сангийн эргэлтэнд орлоо гэсэн үг, өөрөөр хэлбэл хүмүүс түүнийг тэр чигээр нь



хэм хэмжээ, стандарт мэтээр ойлгож хүлээн авах нь гарцаагүй. Харин 2013 онд хэвлэгдсэн Ч. Зундуйсүрэн нарын “Шинжлэх ухаан техникийн тайлбартай толь бичиг (англи, орос, монгол, хятад)” нь нэр томьёог нэг мөр болгож тогтооход ач тусаа өгөх бүтээл болжээ. Цаашид нэр томьёоны толь боловсруулж хэвлүүлэх ажлыг журамлах, хэл шинжлэлийн болон тухайн салбарын эрдэмтдийн үнэлэлт дүгнэлтэд үндэслэн шийдвэрлэдэг болох шаардлагатай байна.

“Нэр томьёо нь тусгай зориулалтын, мэргэжлийн, явцуу, нэг хүрээнд ашигладаг, тусгай мэдлэгийг агуулсан, ганц утгатай шинжлэх ухааны тодорхойлолтой байна” (Болд, 2009, х.145) Нэг нэр томьёо зөвхөн нэг ойлголт ухагдахууныг илэрхийлэх ёстой бөгөөд ижил утга ухагдахуун байх ёсгүй юм. (Bernard Spolsky, 1998, p.66)

Дэлхийн олон улс орон үндэсний хэмжээний шинжлэх ухаан, техник технологийн нэр томьёоны цахим сан бүрдүүлж, улмаар хэд хэдэн сая нэр томьёог олон хэлээр орчуулан байршуулсан байдаг. Тэдгээр нэр томьёоны ихэнх нь стандартчилагдсан байдаг байна. Учир нь интернэт сүлжээн дэх файл хэлбэрийн нэр томьёог нэг стандартад оруулах, оноон жигдлэхэд хялбар төдийгүй тэдгээр стандартчилагдсан нэр томьёог олон нийт хэрэглэж хэвших өргөн боломж бүрдэх юм.

Мэргэжлийн салбар хоорондын нэр томьёог хоорондоо утга ухагдахуун давхцахгүй байхаар нарийвчлан ангилах шаардлагатай байна. Жишээ нь: Канад улсын нэр томьёоны цахим санд “Power energy balance - Эрчим хүчний баланс” хэмээх нэр томьёо англи, франц, испани хэл дээр дараах 4 өөр салбарт 4 өөр ухагдахуунаар хэрэглэгдэж байна. Үүнд:

1. Хүрээлэн буй орчны эдийн засаг- Environmental Economics
2. Эрчим хүчний өөрчлөлт- Energy Transformation
3. Салхины эрчим хүч -Wind Energy
4. Аж үйлдвэр- Industries – General

Дээрх 4 салбарын ухагдахуун бүр тодорхойлолт, тайлбар, ишлэл, эх сурвалжаар баталгаажуулагдсан байна.

Хүснэгт 1, 2-т нэр томьёоны сан үүсгэх загварыг англи, монгол хэл дээр харууллаа.

Хүснэгт 1

Geothermal power station- Газрын гүний цахилгаан станц гэх нэр томьёоны файл

Монгол	Англи
<p>Холбогдох салбар: – Геотермийн эрчим хүч – Дулааны цахилгаан станц Газрын гүний цахилгаан станц Тодорхойлолт – Газрын гүний усны дулааны эрчим хүчийг цахилгаан буюу дулааны эрчим хүч болгон хувиргах зориулалттай нэгэн төрлийн дулааны цахилгаан станц Эх сурвалжын тоо: 1 Зундуйсүрэн.Ч. “Шинжлэх ухаан техникийн тайлбартай толь бичиг”, Уб., 2013</p>	<p>Subject Field(s) – Geothermal Energy – Thermal Power Stations Geothermal power station DEF – A power station or plant [that] converts geothermal energy into electrical energy. Number of Sources: 1 Energy dictionary = Dictionnaire de l'énergie = Energiewörterbuch = Diccionario de la energia. World Energy Council. [Paris] : World Energy Council = Conseil mondial de l'énergie, 1992.</p>

Эх сурвалж: О. Мягмарсүрэн “Үндэсний нэр томьёоны цахим сан 2015”, termiumplus.gc.ca.

Хүснэгт 2

Hydropower station- усан цахилгаан станц гэх нэр томъёоны файл

Монгол	Англи
<p>Холбогдох салбар: – Усан цахилгаан станц – Эрчим хүч (физик) – Ус цаг уур Усан цахилгаан станц Тодорхойлолт – Усны урсгалын механик эрчмийг цахилгаанд хувиргах зориулалттай тоног төхөөрөмж, шугам сүлжээ, барилга байгууламжийн нэгдэл</p> <p>Эх сурвалжын тоо: 1</p> <p>Зундуйсүрэн.Ч. “Шинжлэх ухаан техникийн тайлбартай толь бичиг”, Уб., 2013.</p>	<p>Subject Field(s) – Hydroelectric Power Stations – Energy (Physics) – Hydrology and Hydrography Hydropower station DEF – Electrical energy generated by means of a power generator coupled to a turbine through which water passes. Number of Sources: 1 Glossary of geology / Robert L. Bates and Julia A. Jackson, editors. Bates, Robert Latimer, 1912- .Falls Church, Va. : American Geological Institute, 1980</p>

Эх сурвалж: О. Мягмарсүрэн “Үндэсний нэр томъёоны цахим сан 2015”, termiumpplus.gc.ca

Судалгааны үр дүн

Үндэсний нэр томъёоны стандарт бүхий цахим сан боловсруулахад нэр томъёоны файл маш чухал юм. Бидний түүвэрлэсэн нийт нэр томъёоны 1138 буюу 94,8% нь стандартчилагдаагүй, 645 нэр томъёо буюу 53,7% нь ямар нэг тайлбар, тодорхойлолт байхгүй байна. Салбарын мэргэжилтнүүд хоорондоо нэг нэр томъёог олон янзаар тайлбарлаж байгаа бөгөөд шинжлэх ухааны салбар бүр дээр нэр томъёог цэгцлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Үндэсний стандартчиллын байгууллагын санд нэр томъёоны стандарт ердөө 159 ширхэг байгаа гэсэн судалгааг стандарт хэмжилзүйн үндэний төв гаргасан байдаг. Нийт стандартын ердөө 3% нь нэр томъёоны стандарт байна. Гэтэл Канадын нэр томъёоны цахим санд сар болгон стандартчилагдсан 4000 гаруй нэр томъёо шинээр нэмэх, нэмэлт засвар тайлбар оруулж байдаг байна. Нэр томъёоны техникийн хороо сар бүр цахим хурал хийж бүх асуудлаа хурдан шуурхай шийдвэрлэдэг.

Гэтэл манай стандартчилагдсан нэр томъёо холбогдох техникийн хороогоор хэдийд ч засварлагдаж болох ба таван жил тутамд шалгагдаж улмаар засварлагдаагүй тохиолдолд дахин батлагдах эсвэл хасагдах ёстой байдаг ч таван жилийн дараа шалгах хүртэл барагтай л бол нэмэлт засвар ордоггүй байна. Үүний тод жишээ бол Эрчим хүчний салбарт хамгийн сүүлд 2003 онд “Эрчим хүч ба цахилгаанжуулалт”, нэр томъёо тодорхойлолт, MNS 2919-2003 гэсэн стандартаас өөр стандарт одоо болтол нэмэгдээгүй байна. Шинэ нэр томъёо үүсгэх, түүнийг тогтоох, стандартчилах байтугай хэрэглэгдэж байгаа нэр томъёогоо цэгцлэх үйл ажиллагааны хурд бодит хэрэгцээнээс хамаагүй хоцорч байна. Тиймээс шинжлэх ухааны салбар бүрт нэр томъёог боловсруулах ажлыг нэг тогтолцоонд оруулан, хамтын өргөн хүрээний бүтээл болгож салбарын эрдэмтдэд нээлттэй цахим хэлэлцүүлэг хийж боловсруулан, бидний санал болгож буй үндэсний нэр томъёоны стандартын жишгээр жигдлэн боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Балдан, Л. (2005). Нэр томъёог нөхөх, үл нөхөх зарчмаар судлах нь. *Нэр томъёо судлал* №7. Улаанбаатар.
- Баярсайхан, Ё. (2005). Нэр томъёоны тулгамдсан асуудалд. *Нэр томъёо судлал* №7. Улаанбаатар.
- Болд, Д. (2009). Шинжлэх ухаан, технологийн нэр томъёоны өгөгдлийн сан байгуулах нь. *ШУТИС-ХБС ЭШ бичиг* №2. Улаанбаатар.
- Гүрбазар, Р. (1996). *Орчуулгын онол дадлагын үндэс*. Улаанбаатар.
- Гэрэлмаа, Г. Шинэбаяр, О. (2014). *Монгол нэр томъёо судлалын товчоо*. Улаанбаатар.
- Гэрэлмаа, Г. (2012). *Хэрэглээний хэл шинжлэл*. Улаанбаатар.
- Гэрэлмаа, Г. (2009). Техник, технологийн нэр томъёог оноох, жигдлэх тухайд. *ШУТИС-ХБС-ийн ЭШБ* №2. Улаанбаатар.
- Дашдаваа, Д. (1977). *Орчуулгын зарим асуудал*. Улаанбаатар.
- Догсүрэн, Ч. (1988). *Монгол нэр томъёо оноох, толилох, жигдлэх асуудалд*. Улаанбаатар.
- Жамба, Г. (2005). *Нэр томъёо судлал* №7. Улаанбаатар.
- Зээнямбуу, Ч. (2014). *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар.
- Зундуйсүрэн, Ч. (2013). *Шинжлэх ухаан техникийн тайлбартай толь бичиг*. Улаанбаатар.
- Мөнхцэцэг, Н., Шинэбаяр О. (2014). *Монгол нэр томъёо судлал 90*. Улаанбаатар
- Мягмарсүрэн, О. (2015). Хэлний бодлого төлөвлөлтийн хүрээнд техникийн хэлийг боловсронгуй болгох, стандартчилах асуудалд. *МУБИС-НХУС ЭШБ эмхэтгэл*, №2. Улаанбаатар.
- Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо. (2006). *Стандарт хэмжилзүйн үндэсний төв*. MNS1-2:2006. Улаанбаатар
- Монгол улсын стандартын жагсаалт. (2013). *Стандартчилал хэмжилзүйн үндэсний төв*. Улаанбаатар.
- Нэр томъёо судлал. (2012). №14. ШУА. Хэл зохиолын хүрээлэн. Улаанбаатар.
- Өнөрбаян, Ц. (1999). Шинжлэх ухааны нэр томъёог журамлах тухай асуудалд. Нэр томъёо судлал. ШУА Хэл зохиолын хүрээлэн. Улаанбаатар
- Өнөрбаян, Ц. (2005). ШУА Хэл зохиолын хүрээлэн. Нэр томъёо судлал №7. Улаанбаатар.
- Равдан, Э. (2013). Хэрэглээний хэлшинжлэл, хэл сурахуйн онол. МУИС-ГХСС. Улаанбаатар.
- Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.
- Шинэбаяр, О. (2012). Нэр томъёо судлал, ШУА Хэл зохиолын хүрээлэн. Улаанбаатар.
- Эрчим хүч ба цахилгаанжуулалт. (2003). Нэр томъёо, тодорхойлолт, Стандартчилал хэмжилзүйн үндэсний төв. MNS 2919 - 2003. Улаанбаатар
- Bernard, Spolsky. (1998). *Applied sociolinguistics*. Editor Widdowson H. G. Oxford university press.
- Hornberger, N. H. (1994). *Literacy and Language Planning*. Editor Teresa L McCarty. Berlin.
- Nahir, Moshe. (2003). *Micro-corpus codification in the Hebrew Reviva*. No. 5. Department of linguistics. University of Manitoba, Canada.
- Thomas, Ricento. (2006). *An introduction to language policy. Theory and method*. Oxford, published by Blackwell.
- Cit 05/11/2015, [http:// www. Termiumplus. gc. ca](http://www.Termiumplus.gc.ca). Public works and government services Canada. 11 Laurier street.